МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр Дугаар А/129 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай" 81 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 92 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2022 оныг хоршооны хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан, хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажилтай уялдуулж хоршооны үйл ажиллагааг сурталчлах, идэвхжүүлэх, гишүүдийг сургаж чадавхжуулах, хоршоог үнэлэх, хоршооны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар батлсугай.

2. Хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр, хоршооны хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг жил бүрийн 2, 4 дүгээр улиралд багтаан Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 04
дүгээр сарын 27-ны өдрийн А/129
дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	(Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Гишүүд :	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөдөө аж ахуй, хүнс, худалдааны асуудал хариуцсан мэргэжилтэн)
	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
	(Сумдын Засаг дарга нар)
	(Аймгийн Татварын хэлтсийн Бичил татвар төлөгчийн хэлтсийн дарга)
	(Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгч)
	(Аймгийн худалдаа эд хэрэглэгчдийн хоршоодын холбооны дарга)
	(Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны дарга)
	(Аймгийн үйлдвэрлэлийн хоршооллын холбооны дарга)
	(Аймгийн үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбооны дарга)
Нарийн бичгийн дарга:	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг дунд, хөнгөн үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

_____oOo_____